

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны ... дугаар сарын ... –ны өдөр      Дугаар ...      Улаанбаатар хот

Усны үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Усны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Усны асуудлаарх салбар дундын зохицуулалт хийх, нэгдсэн удирдлагаар хангах, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах үүрэг бүхий Усны үндэсний хорооны бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн байгуулсугай:

Үндэсний хорооны дарга:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;

Гишүүд:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Үндэсний хорооны дарга:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;

Нийслэлийн Засаг даргын орлогч;

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга;

“Монгол Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал;

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга;

Нарийн бичгийн дарга:

(орон тооны)

2. Усны үндэсний хорооны дүрмийг шинэчлэн баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Үндэсний хорооны дарга Д.Оюунхоролд даалгасугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт, “Тогтоолын

хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 409 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ